

ГАРЧАГ

Төслийн товч танилцуулга.....	2
Төслийн зорилго, ач холбогдол	4
Төслийн үр дүнгийн товчоо	4
Үр дүн-1: “Цог” сэтгүүлийн 342 дугаарыг цахимжуулсан үйл явц	4
Цог сэтгүүлийн цахим хэлбэр: (1944-2021).....	5
Цог – 1944-1970: DVD-4	6
Цог – 1971-2010: DVD-4	7
Цог – 2011-2021 ба ”Zotero”-д шивсэн эх: DVD-2.....	8
Цог сэтгүүлийн дугаар тус бүрийг цахимжуулсан загвар	9
Цог сэтгүүлийн нийтлэлийн судалгааны тойм (1944-1921)	9
Цог сэтгүүлийн дугаарыг цахимжуулах үйл явц.....	16
Үр дүн 2: 7042 нийтлэл тус бүрнau “Zotero” программд оруулсан үйл явц.....	17
Цог сэтгүүлийн нийтлэлийг “Zotero” програмд оруулсан загвар ба өгөгдлийн нэрийн оногдуулалт	17
Цог сэтгүүлийн нийтлэлийг /1947 он/ “Zotero”- д оруулсан загвар	18
Цог сэтгүүлийн цаасан картын сан (1944-2021)	19
Үр Дүн 3: Цог сэтгүүлийн нийтлэлийн хэвлэмэл гарын авлага	20
Мэдээллийн санг ашиглахад анхаарах зүйл.....	20
Төгсгөл: Цог сэтгүүлийн гаралтын мэдээний тойм.....	21
Талархал.....	23

“ЦОГ” СЭТГҮҮЛИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САН” ТӨСЛИЙН ТАЙЛАН

Төслийн товч танилцуулга:

Төслийн эхлэл ба явц:

2020 оны 1-р сард ШУА-с СУИС-ийн Соёлын сургуулийн Номын сан судлалын тэнхмийн багш Ж.Цэзэнгийн хувийн цуглуулга дахь “мэдээллийн сан”-гийн нөөцтэй биечлэн танилцсанаар энэхүү төсөл хэрэгжих болсон. Төслийн саналыг дэмжсэн албан тоотууд гарч ШУА-д хүргүүлсэн:

1. СУИС-ийн СС-ийн ЭЗ-ийн хурлын 2020 оны 02-р сарын 18-ны өдрийн №3 тоот тогтоолоор төслийн санал дэмжигдэн, ШУА-д 2020 оны 02 сарын 27-нд “Төслийн санал хүргүүлэх” албан тоот илгээсэн.

2. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс уг төслийг дэмжсэн, хамтран ажиллах саналыг 2020 оны 03-р сарын 3-нд 01/53 тоот албан бичгээр ШУА-д хүргүүлсэн

3. 2020 оны 06-р сарын 03-нд “Цог сэтгүүлийн цахим мэдээллийн сан” төсөл батлагдаж, Дугаар: **ШУА -2020/19** гэрээг хийсэн: (Хавсралт №1)

а/ Захиалагч: ШУА-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Б.Авид

б/ Сахүүжүүлэгч: ШУТС-ийн захи рал М.Тунгалаг

в/ Гүйцэтгэгч: СУИС-ийн Соёлын сургуулийн захи рал Б.Баяраа

г/ Төслийн Эрдэм шинжилгээний зардал: 6,000,0

д/ Төслийн удирдагч: Ж.Цэзэн (Sc.D), профессор

Төслийн гүйцэтгэл:

Төслийн санхүүжилт 2021 оны 12-р сарын 28-нд СУИС-ийн Соёлын сургуулийн албан дансанд шилжиж орсноор хуучин байсан мэдээллийн санг үргэлжлүүлэн хийх ажил эрчимжиж, 2023 оны 2-р сард дууссан болно.

Төслийн явц болон гүйцэтгэлийн талаар Соёлын сургуулийн захиргааны зөвлөл, эрдмийн зөвлөлийн хурлаар удаа дараа хэлэлцүүлж, хүн хүч нэмэгдүүлэх, ажлын байр, тав тухтай орчин нөхцлөөр хангах талаар дэмжин тусалж, гүйцэтгэлийг ЭЗХ-ар эцэслэн хэлэлцэж, хурлын тогтоол, албан тоотоор төсөл дууссаныг танилцуулсан.

Төсөл гүйцэтгэсэн багийн танилцуулга:

Төсөл захиалагч байгууллага: ШУА

Төсөл санхүүжүүлэгч байгууллага: ШУТС

Төсөл гүйцэтгэгч байгууллага: СУИС-ийн Соёлын сургууль
Монголын номын сангийн “Арван ухаан” холбоо

Төслийн удирдагч: Ж.Цэзэн (Sc.D), профессор.

Төслийн багийн мэргэжлийн зөвлөл:

Б.Тунгалаг (Ph.D), дэд профессор /МУҮНС/
Д.Мандах (Ph.D), профессор /СС-ийн Эрдэмтэн
нарийн бичгийн дарга/
А.Мөнхцацал (докторант) (Номын сан-
мэдээлэлзүйч)

Санхүүгийн зохицуулагч:

Н.Ургамал (Соёлын сургуулийн нягтлан бодогч)

Багийн гишүүд:

Э.Ууганбаяр (Магистрант) СС-ийн номын санч
Чимэдцэрэн (Магистр) -/МУИС-ийн номын сан/
Н.Пагмадулам (Магистр -/МУҮНС/
Б.Бүжинлхам, Д.Шинэчимэг (Номын сан мэдээлэлзүйч)
Дадлагын оюутан, магистрант нар (2018-2021)

Төслийн зорилго:

“Цог” сэтгүүлд 77 жилийн хугацаанд хэвлэгдсэн Монгол болон гадаадын орчуулгын уран зохиол, утга зохиолын судлал шүүмжлэл, дуртгал тэмдэглэл, бодлого шийдвэр зэрэг өгүүлэл нийтлэлийн цахим мэдээллийн нэгдсэн нөөцийг буй болгож, цахимаар уншиж ашиглуулах, сургалт, судалгааны эргэлтэнд оруулах.

Төслийн ач холбогдол:

- Цаасан суурьтай эх баримтыг цахимаар унших боломж бүрдсэн, мэдээллийг хурдан шуурхай, нэг дороос авах болсон;
- Сэтгүүлийн мэдээлэл устаж үгүй болохоос хамгаалагдсан;
- ХХ зууны Монголын утга, уран зохиолын салбарын хөгжлийн төлөв байдалд анализ хийж дүгнэх, статистик бодит мэдээ, баримтын нөөц буй болсон;
- Утга, уран зохиолын мэргэжилтэн, судлаач нарт бодит мэдээллийг практикт ашиглах боломж бүрдсэн;
- Бусад салбарын мэдээллийн нөөцийг буй болгох загвар, туршлага буй болсон;
- “Цог” сэтгүүл нь салбартаа илүү нэр хүнд, статустай сэтгүүл тул энэхүү мэдээллийн нөөцийг үндэслэн олон улсын үнэ цэнэ өндөртэй (IF) сэтгүүлийн түвшинд хүрэх боломж бүрдсэн ач холбогдолтой.

Төслийн үр дүн


- 1. Цог сэтгүүлийн 342 дугаарын 47.319 хуудас баримт цахимд оруулсан**
- 2. 342 сэтгүүлийн 7042 өгүүлэл нийтлэл тус бүрд товч тайлбар бичиж “ZOTERO” цахим программд шивж оруулсан**
- 3. 1944-2021 он хүртэл хэвлэгдсэн “Цог” сэтгүүлийн нийтлэлийг нэгтгэн эмхтгэж боловсруулан 2 дэвтэр болгон тус бүр 2 % хэвлүүлсэн**

Үр дүн-1: “Цог” сэтгүүлийн 342 дугаарыг цахимжуулсан үйл явц

Юуны өмнө “Цог” сэтгүүлийн нийтлэлийг цахимжуулах, нэгдсэн мэдээллийн санг буй болгох ажлыг санхүүжүүлж төсөл хэрэгжүүлэх боломж олгосон ШУА, ШУТС-ийн холбогдох хүмүүст талархлаа илэрхийлье. Учир нь тус сэтгүүлийн анх гарсан үеэс өдгөө болтол бараг 80 жил болох гэж байгаа тул хэвлэлийн эх муудаж, зарим хуудас, дугаар үрэгдэж үгүй болсон, хуучирсан цаасан хэвлэлийг уншихад төвөгтэй, бас олдоцгүй зэрэг асуудлыг шинэчилж, хэвлэлийн эхийг цахимаар унших, мэдээллийг нэг дороос хайх боломж олгосон нь цаг хугацаа, эдийн засаг, хадгалалт хамгаалалтын гэх мэт олон талын ач холбогдолтой боллоо.

Зөвхөн цахим хэлбэрт шилжүүлээд зогсохгүй, сэтгүүлийн нийтлэлийн агуулга, гаралтын мэдээ, редакцийн ажилд дүн шинжилгээ хийх боломж бүрдсэн, цаашид ХХ зууны Монголын утга, уран зохиолын түүхэн хөгжил хийгээд хэтийн чиг хандлагыг судлах зэрэг ажилд тус дөхөм болохуйц номзүйн товч тодорхойлолт бүхий цахим болон цаасан хэвлэлийн эх бэлэн болсон явдал нь төслөөр гүйцэтгэсэн ажлын үр дүн, ач холбогдол болно. Нөгөө талаар Монгол улсад ХХ зууны эхнээс үүсэн хөгжиж, өдгөө уншигчдын эрэлт хэрэгцээ, хүлээлттэй байгаа бусад сэтгүүлийн нийтлэлийн мэдээллийн санг бүрдүүлэх туршлага хуримтлагдсан нь олон улсын тогтмол хэвлэлийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах жишигт хүрэх боломж олгоно гэж үзэж байна. Төслийн хүрээнд хийгдсэн “Цог сэтгүүлийн цахим мэдээллийн сан”-д нийт 1944-2021 оны 77 жилийн баримт хамрагдсан байдлыг зургаар товч харуулбал:

Зураг №1: “Цог” сэтгүүлийн цахим хэлбэр: (1944-2021)



Зураг №1а: “Цор” – 1944-1970: DVD-4




Зураг №16: “Цог” – 1971-2010: DVD-4



Зураг №1в: “Цог” – 2011-2021 ба ”Zotero”-д шивсэн эх: DVD-2



Зураг №1г: “Цог” сэтгүүлийн дугаар тус бүрийн цахим хэлбэр:



“Цог” сэтгүүлийн нийтлэл тус бүрийг судалж, хүснэгтээр ангилан харуулбал:

Хүснэгт № 1

“Цог” сэтгүүлийн нийтлэлийн судалгааны тойм (1944-1921)

№	Он	Дугаар	Өгүүлийн тоо	Сэтгүүлийн хуудас	Тэргүүн	Судлал шүүмжлэл	Дуртгал тэмдэглэл	Яруу найраг	Үргэлжилсэн үг	Тойм мэдээ /өлтөгц/	Монгол	Гадаад /орчуулга/
1	1944	№1	16	70	1	2	2	3	8		15	1
		№2	10	54	1		1	2	6		7	3
		№3-4	14	51	1	1	1	2	9		13	1
		4	40	175	3	3	4	7	23		34	6
2	1945	№ 5-6	14	52	1		1	5	7		12	2
		№ 7	10	81		1	2		7		9	1
		3	24	133	1	1	3	5	14		21	3
3	1946	№ 8- 9	10	45			1	6	3		8	2
		2	10	45			1	6	3		8	2
4	1947	№1	11	83	1	1	1	4	4		10	1
		№2-3	14	138	1	2		6	5		14	0
		3	25	221	2	3	1	10	9		24	1
5	1948	№1	14	140	2	1		2	7	2	10	4
		№2	18	78	1	4		4	9		16	2
		№3-4	8	84		1		4	3		7	1
		4	40	302	3	6	0	10	19	2	33	7
6	1949	№1-2	20	122		2	1	11	7		9	11

		№3	9	104	1	1		3	4		7	2
		№4	14	58				7	7		10	4
		4	43	284	1	3	1	21	18		26	17
7	1950	№1	14	115		1		5	8		10	4
		№2	14	101		1	1	4	7	1	9	5
		№3-4	13	115	2	1		5	5		11	2
		4	41	331	2	3	1	14	20	1	30	11
1945-1950		24	223	1491	12	19	11	73	106	3	176	47
8	1951	№1	13	106	2	1		5	5		11	2
		№2-3	13	166	1	2	1	5	4		13	0
		3	26	272	3	3	1	10	9	0	24	2
9	1952	№1	29	107	8	1	1	13	6		19	10
		№2	14	96	1	2		7	4		13	1
		№3	16	103	2	2		7	5		5	11
		3	59	306	11	5	1	27	15	0	37	22
10	1953	№ 1	19	102	2	2		7	8		11	8
		№ 2	27	100	10		1	7	8	1	16	11
		№ 3	14	80	2	3	2	5	2		9	5
		№ 4	19	124	2	3	1	9	4		13	6
		4	79	406	16	8	4	28	22	1	49	30
11	1954	№ 1	14	107	3	1		8	2		12	2
		№ 2	15	120		3		8	4		9	6
		№ 3	33	183	1	1		25	4	2	13	20
		№ 4	14	115		3		7	4		5	9
		№ 5-6	22	146		3		14	5		16	6
		6	98	671	4	11	0	62	19	2	55	43
12	1955	№ 1	13	139	2	3		2	6		11	2
		№ 2	14	96	1	3		8	2		13	1
		№ 3	14	117		1		4	9		8	6
		№ 4	19	104		1	1	12	4	1	11	8
		№ 5	17	148		2	1	9	5		11	6
		№ 6	20	128		5	4	5	3	3	17	3
		6	97	732	3	15	6	40	29	4	71	26
13	1956	№ 1	25	117	1	8	5	6	3	2	19	6
		№ 2	18	89	1	3	3	7	2	2	14	4
		№ 3	16	100	1	4		3	6	2	15	1
		№ 4	16	90		4	1	5	6		15	1
		№ 5	14	105	1	2		6	5		10	4
		№ 6	13	112		4		5	2	2	10	3
		6	102	613	4	25	9	32	24	8	83	19
14	1957	№ 1	15	122		3		7	3	2	12	3
		№ 2	12	113	1	2		3	5	1	9	3
		№ 3	12	96	2	4		3	2	1	10	2
		№ 4	14	75		3	1	4	6		13	1
		№ 5	26	95	2	4		10	7	3	21	5
		№ 6	21	104	2	2	3	9	5		15	6
		6	100	605	7	18	4	36	28	7	80	20
15	1958	№ 1	13	95	1	3		5	4		11	2
		№ 2	23	107	1	3	1	11	7		22	1
		№ 3	17	96	1	3		8	4	1	16	1
		№ 4	22	104	3	3		9	7		11	11
		№ 5	16	99		4		8	3	1	14	2
		№ 6	16	83		4		7	5		14	2
		6	107	584	6	20	1	48	30	2	88	19
16	1959	№ 1	14	87	2	3	1	4	4		12	2
		№ 2	20	123	1	4	1	5	6	3	15	5
		№ 3	16	124	1	2	2	5	6		14	2
		№ 4	25	126	1	2	4	12	6		23	2
		№ 5	17	132		4		6	7		15	2
		№ 6	18	110	1	1	3	8	4	1	15	3
		6	110	702	6	16	11	40	33	4	94	16
17	1960	№ 1	15	123	1	1		8	5		12	3
		№ 2	17	96		2	2	10	3		11	6
		№ 3	15	123				9	6		13	2
		№ 4	13	134	1	4		2	6		12	1
		№ 5	12	124		4		3	5		10	2
		№ 6	20	106	2	4	2	6	6		19	1
		6	92	706	4	15	4	38	31	0	77	15

1951-1960		52	870	5597	64	136	41	361	240	28	658	212	
18	1961	№ 1	20	116	1	3		5	9	2	16	4	
		№ 2	19	107		5	1	7	5	1	10	9	
		№ 3	19	115	1	1	3	7	7			15	4
		№ 4	15	100	1	3		4	6	1	14	1	
		№ 5	13	107			2	1	5	4	1	9	4
		№ 6	14	100				1	3	8	2	10	4
		6	100	635	3	14	6	31	39	7	74	26	
19	1962	№ 1	13	115	1		1	4	4	3	11	2	
		№ 2	30	119	1	2	4	14	7	2	27	3	
		№ 3	17	107	2	1	3	9	1	1	14	3	
		№ 4	16	102		2	1	4	8	1	12	4	
		№ 5	14	96	1	2	1	5	4	1	12	2	
		№ 6	21	118	1		3	6	9	2	17	4	
		6	111	657	6	7	13	42	33	10	93	18	
20	1963	№ 1	18	125	1	3	1	3	8	2	14	4	
		№ 2	16	96	1	2	1	7	3	2	15	1	
		№ 3	16	138	1	4		5	5	1	15	1	
		№ 4	22	100		3		11	7	1	20	2	
		№ 5	19	108	1	1		8	8	1	14	5	
		№ 6	25	108	1	1	5	12	5	1	13	12	
		6	116	675	5	14	7	46	36	8	91	25	
21	1964	№ 1	14	141		2	4	4	3	1	12	2	
		№ 2	17	119		2	1	5	8	1	15	2	
		№ 3	21	122	1	2	1	6	10	1	15	6	
		№ 4	16	130	1	2	1	5	6	1	14	2	
		№ 5	15	117		1	1	4	8	1	12	3	
		№ 6	18	122	2	2	2	5	6	1	15	3	
		6	101	751	4	11	10	29	41	6	83	18	
22	1965	№ 1	12	100		2		2	7	1	10	2	
		№ 2	24	127		3		10	10	1	18	6	
		№ 3	25	116			1	13	10	1	17	8	
		№ 4	28	152		1	1	16	9	1	19	9	
		№ 5	17	159	1	2	1	7	5	1	12	5	
		№ 6	14	171		2		6	5	1	13	1	
		6	120	825	1	10	3	54	46	6	89	31	
23	1966	№ 1	19	167	1	2	2	7	6	1	16	3	
		№ 2	21	156		1	1	12	6	1	11	10	
		№ 3	20	168	1	1		12	5	1	13	7	
		№ 4	13	195	1	1	1	5	4	1	9	4	
		№ 5	28	182	1	4	2	13	8		24	4	
		№ 6	43	181		4		27	11	1	26	17	
		6	144	1049	4	13	6	76	40	5	99	45	
24	1967	№ 1	16	186	1			8	6	1	14	2	
		№ 2	17	191		4	1	5	5	2	16	1	
		№ 3	16	151	1	1	1	4	7	2	15	1	
		№ 4	23	176	2	2		10	7	2	15	8	
		№ 5	23	198	1	1	1	13	6	1	17	6	
		№ 6	19	183		2	1	7	7	2	17	2	
		6	114	1085	5	10	4	29	38	10	94	20	
25	1968	№ 1	19	185		2		7	8	2	16	3	
		№ 2	19	190	2	2	1	5	7	2	16	3	
		№ 3	21	193		2	1	13	4	1	18	3	
		№ 4	21	185		2	1	8	8	2	18	3	
		№ 5	17	196			1	7	8	1	14	3	
		№ 6	17	187	1	3		8	4	1	15	2	
		6	114	1136	3	11	4	48	39	9	97	17	
26	1969	№ 1	24	203	3	1	2	8	9	1	23	1	
		№ 2	25	191		1		9	14	1	20	5	
		№ 3	24	197		1	1	10	11	1	20	4	
		№ 4	20	172		2	1	10	6	1	15	5	
		№ 5	19	183	1	2		9	6	1	14	5	
		№ 6	18	197	1		1	5	10	1	18	0	
		6	130	1143	5	7	5	51	56	6	110	20	
27	1970	№ 1	20	188	1	1	1	10	6	1	14	6	
		№ 2	18	189	2	2	2	4	7	1	17	1	
		№ 3	25	177		3		12	9	1	23	2	
		№ 4	21	168	1	1	1	9	8	1	15	6	

		№ 5	16	192	1	2		6	6	1	15	1
		№ 6	11	174	1			4	5	1	10	1
		6	111	1088	6	9	4	45	41	6	94	17
1961-1970		60	1161	9044	42	106	62	451	409	73	924	237
28	1971	№ 1	15	174	2	1		6	5	1	14	1
		№ 2	14	157	1	2		6	4	1	14	0
		№ 3	23	187	1	2		11	7	2	23	0
		№ 4	18	179	2	3	1	5	6	1	16	2
		№ 5	15	189		1		8	5	1	14	1
		№ 6	16	176	2	2		6	5	1	12	4
		6	101	1062	8	11	1	42	32	7	93	8
29	1972	№ 1	22	175	1	2		12	6	1	16	6
		№ 2	20	197		4		6	9	1	16	4
		№ 3	16	197	1	2	2	5	5	1	15	1
		№ 4	15	197		4		5	5	1	14	1
		№ 5	20	182		3		9	7	1	17	3
		№ 6	21	187	1	3		13	3	1	15	6
		6	114	1135	3	18	2	50	35	6	93	21
30	1973	№ 1	20	198	1	2	4	8	4	1	17	3
		№ 2	15	192	1	3		6	4	1	14	1
		№ 3	21	176	4	2		6	8	1	18	3
		№ 4	26	167	4	2		11	8	1	12	14
		№ 5	20	169	2	2	1	10	4	1	12	8
		№ 6	19	160		2	1	11	4	1	12	7
		6	121	1062	12	13	6	52	32	6	85	36
31	1974	№ 1	18	170	1	2		5	9	1	13	5
		№ 2	17	173		5		7	4	1	11	6
		№ 3	16	165		3		8	4	1	13	3
		№ 4	15	161	1	3		6	4	1	12	3
		№ 5	15	171		2		8	4	1	13	2
		№ 6	15	171	2	1		6	5	1	12	3
		6	96	1011	4	16	0	40	30	6	74	22
32	1975	№ 1	18	178	3	3		7	4	1	16	2
		№ 2	20	198	1	2	1	10	5	1	14	6
		№ 3	20	200	2	4		6	7	1	16	4
		№ 4	23	176	2	2	2	9	7	1	17	6
		№ 5	16	164		3	1	5	6	1	14	2
		№ 6	30	180		2	1	18	8	1	27	3
		6	127	1096	8	16	5	55	37	6	104	23
33	1976	№ 1	14	135	3	1	1	6	2	1	13	1
		№ 2	13	176	1	2	1	4	4	1	11	2
		№ 3	18	189	2	1	1	6	7	1	17	1
		№ 4	14	185	3	2	1	3	4	1	13	1
		№ 5	22	176	2	4	1	8	6	1	20	2
		№ 6	21	176	1	3		9	7	1	17	4
		6	102	1037	12	13	5	36	30	6	91	11
34	1977	№ 1	14	167	1	2	1	4	5	1	12	2
		№ 2	14	167	1	2	1	4	5	1	12	2
		№ 3	17	173	1	3	1	5	6	1	15	2
		№ 4	13	168	1	1	1	6	3	1	12	1
		№ 5	22	182	1	1		17	2	1	12	10
		№ 6	11	172		2	1	4	3	1	10	1
		6	91	1029	5	11	5	36	24	6	73	18
35	1978	№ 1	18	169	1	4	1	6	5	1	15	3
		№ 2	17	160	1	3	1	7	4	1	14	3
		№ 3	16	186		4	1	5	5	1	14	2
		№ 4	14	169	1	2	1	5	4	1	10	4
		№ 5	20	169	1	5	1	5	7	1	17	3
		№ 6	25	170	1	4		14	5	1	21	4
		6	110	1023	5	22	5	42	30	6	91	19
36	1979	№ 1	20	182	3	1	2	9	4	1	16	4
		№ 2	16	173	2	3	1	5	4	1	13	3
		№ 3	25	184	2	1	1	15	5	1	12	13
		№ 4	21	178	1	3	4	9	3	1	17	4
		№ 5	21	194	1	2	2	8	7	1	17	4
		№ 6	22	172	2	1	3	8	7	1	18	4
		6	125	1083	11	11	13	54	30	6	93	32
37	1980	№ 1	14	131	1	2	2	5	3	1	13	1

		№ 2	16	178	2	1	3	5	4	1	15	1
		№ 3	19	163	2	2	3	6	5	1	18	1
		№ 4	56	172	1	5	2	38	9	1	12	44
		№ 5	21	163		2	1	13	4	1	18	3
		№ 6	15	157	2	2	2	3	5	1	11	4
		6	141	964	8	14	13	70	30	6	87	54
1971-1980		60	1128	10502	76	145	55	477	310	61	884	244
		№ 1	18	148	2	3	1	4	7	1	17	1
		№ 2	18	171	1	1	2	9	4	1	17	1
		№ 3	11	158	1	1	1	5	2	1	10	1
		№ 4	12	178	1	2	2	3	3	1	11	1
		№ 5	12	179	2	1		6	2	1	11	1
		№ 6	12	179		1	2	5	3	1	11	1
		6	83	1013	7	9	8	32	21	6	77	6
38	1981	№ 1	17	173	1	3	2	8	2	1	14	3
		№ 2	16	142		2	2	6	5	1	15	1
		№ 3	17	159	1	5	4	2	4	1	16	1
		№ 4	19	151	1	2	2	8	5	1	16	3
		№ 5	25	158	1	3	2	15	3	1	17	8
		№ 6	17	173	1	3	1	8	3	1	15	2
		6	111	956	5	18	13	47	22	6	93	18
39	1982	№ 1	20	164		2	2	10	5	1	17	3
		№ 2	18	169		3	4	5	5	1	17	1
		№ 3	25	153		2	2	14	6	1	23	2
		№ 4	19	172		2	2	10	4	1	12	7
		№ 5	15	166	1	2	2	5	4	1	14	1
		№ 6	21	158		2	2	11	5	1	19	2
		6	118	982	1	13	14	55	29	6	102	16
40	1983	№ 1	17	166	1	1	3	5	6	1	13	4
		№ 2	26	172	1	2	4	11	7	1	22	4
		№ 3	18	158	1	3	4	3	6	1	17	1
		№ 4	20	168	3	2	2	5	7	1	19	1
		№ 5	20	156	1	2	3	7	6	1	19	1
		№ 6	19	146	1	4	3	5	5	1	17	2
		6	120	966	8	14	19	36	37	6	107	13
41	1984	№ 1	17	167		1	1	9	5	1	15	2
		№ 2	16	163			2	6	7	1	14	2
		№ 3	15	172		2	2	5	5	1	13	2
		№ 4	22	173	1	2	6	5	7	1	21	1
		№ 5	12	163		1	1	4	5	1	11	1
		№ 6	21	165		3	2	10	5	1	15	6
		6	103	1003	1	9	14	39	34	6	89	14
42	1985	№ 1	15	161		2	1	6	5	1	14	1
		№ 2	19	136	1	3	2	7	5	1	17	2
		№ 3	18	165		3	3	6	5	1	17	1
		№ 4	25	170	1	7	1	7	8	1	24	1
		№ 5	15	129		4	2	4	4	1	13	2
		№ 6	15	166		2	1	8	3	1	14	1
		6	107	927	2	21	10	38	30	6	99	8
43	1986	№ 1	15	158		2	1	5	6	1	14	1
		№ 2	16	139		3	2	7	3	1	15	1
		№ 3	16	191		2	4	5	4	1	15	1
		№ 4	18	181		11	1	2	3	1	17	1
		№ 5	26	175		3	2	15	5	1	20	6
		№ 6	15	182		3	3	4	4	1	14	1
		6	106	1026		24	13	38	25	6	95	11
44	1987	№ 1	16	172		1	4	7	3	1	15	1
		№ 2	25	166		3	2	15	4	1	19	6
		№ 3	19	150		3	2	8	5	1	17	2
		№ 4	15	173		2	2	5	5	1	12	3
		№ 5	55	189		3	3	45	3	1	11	44
		№ 6	19	166		3	6	5	3	2	18	1
		6	149	1016		15	19	85	23	7	92	57
45	1988	№ 1	26	174		1	3	17	4	1	25	1
		№ 2	23	170	3	2	1	12	4	1	22	1
		№ 3	18	159		2	2	9	4	1	15	3
		№ 4	21	171		1	1	15	3	1	20	1
		№ 5	22	147		2	2	15	2	1	21	1
46	1989	№ 1	26	174		1	3	17	4	1	25	1
		№ 2	23	170	3	2	1	12	4	1	22	1
		№ 3	18	159		2	2	9	4	1	15	3
		№ 4	21	171		1	1	15	3	1	20	1
		№ 5	22	147		2	2	15	2	1	21	1

		№ 6	48	164		1	2	34	10	1	38	10
		6	158	985	3	9	11	102	27	6	141	17
47	1990	№ 1	25	164		2	3	14	5	1	25	0
		№ 2	20	172		2	3	10	4	1	20	0
		№ 3	21	156		3	2	10	5	1	20	1
		№ 4	23	183		3	3	11	5	1	22	1
		№ 5	35	157		3	2	24	5	1	35	0
		№ 6	24	167		5	3	9	6	1	21	3
		6	148	999	0	18	16	78	30	6	143	5
1981-1990		60	1203	9873	27	150	137	550	278	61	1038	165
48	1991	№ 1	25	182		1	1	14	8	1	15	10
		№ 2	28	127			1	20	6	1	26	2
		№ 3	14	173		1	2	4	6	1	13	1
		№ 4	22	165		1	1	15	4	1	22	0
		№ 5	15	156			2	5	7	1	13	2
		№ 6	19	151		1	3	8	6	1	18	1
		6	123	954		4	10	66	37	6	107	16
49	1992	№ 1	14	125		2	2	6	3	1	14	0
		№ 2	11	122			1	6	4		11	0
		№ 3	13	114		3		6	4		12	1
		№ 4	13	111			1	7	5		10	3
		4	51	472		5	4	25	16	1	47	4
1993-1999*		Хэвлэгдээгүй										
51	2000	№ 1	48	180		1	1	32	15	1	46	2
1991-2000		12	222	1606	0	10	15	123	68	8	200	22
52	2001	№ 1	23	162		1	2	8	10	2	22	1
		№ 2	29	167		2		17	8	2	26	3
		№ 3	44	187		2	14	19	8	1	37	7
		№ 4	26	164		2	2	10	11	1	18	8
		4	122	680		7	18	54	37	6	103	19
53	2002	№ 1	26	153		5		12	7	2	21	5
		№ 2	62	154				49	12	1	62	0
		№ 3	24	151		1	2	12	8	1	19	5
		№ 4	18	144		3	2	2	10	1	12	6
		4	130	602		9	4	75	37	5	114	16
54	2003	№ 1	28	159		2	1	15	8	2	26	2
		№ 2	14	153		1		7	4	2	10	4
		№ 3	21	154		3		9	8	1	11	10
		№ 4	38	158		3		25	9	1	20	18
		4	101	624	0	9	1	56	29	6	67	34
55	2004	№ 1	33	160	1		2	18	8	4	22	11
		№ 2	20	194	2	2		9	5	2	18	2
		№ 3	27	181		2	2	14	7	2	25	2
		№ 4	24	157		3	3	6	10	2	18	6
		4	104	692	3	7	7	47	30	10	83	21
56	2005	№ 1	38	158		5	1	24	6	2	29	9
		№ 2	28	162		2	2	16	6	2	18	10
		№ 3	32	166		2	1	23	4	2	17	15
		№ 4	28	153		1	6	12	7	2	19	9
		4	126	639		10	10	75	23	8	83	43
57	2006	№ 1	36	160		4	3	21	6	2	26	10
		№ 2	33	158		4	2	22	3	2	19	14
		№ 3	53	159	1	5	2	33	10	2	32	21
		№ 4	45	182		4	10	22	7	2	38	7
		4	167	659	1	17	17	98	26	8	115	52
58	2007	№ 1	23	210		1		12	8	2	20	3
		№ 2	29	171		1	1	20	6	1	26	3
		№ 3	33	180		3	4	20	5	1	20	13
		№ 4	58	208		4	2	43	8	1	47	11
		4	143	769		9	7	95	27	5	113	30
59	2008	№ 1	31	105		3	1	21	5	1	20	11
		№ 2	30	122		3	1	18	7	1	22	8
		№ 3	31	158		2	2	14	12	1	26	5

* "Цог" сэтгүүлийн 50 жилийн ой 1994 онд тохиосон учир ойд зориулсан нэг дугаарыг "Соёл урлагийг дэмжих сан"-гийн ивээн тэтгэлэгээр хэвлүүлсэн гэж тэмдэглэсэн ч олдоогүй, МУУНС-д байхгүй байв

		№ 4	26	127	1	6	2	12	4	1	20	6	
		4	118	512	1	14	6	65	28	4	88	30	
60	2009	№ 1	43	130	1	1		28	12	1	37	6	
		№ 2	35	154	3	2		24	5	1	17	18	
		№ 3	38	146	2	1	4		25	5	1	32	6
		№ 4	16	117				1	8	6	1	10	6
		4	132	547	6	4	5	85	28	4	96	36	
61	2010	№ 1	22	133	1	1	2	10	7	1	19	3	
		№ 2	21	167			1	1	12	7		17	4
		№ 3	21	165			2	1	12	6		20	1
		№ 4	29	155	1	2	4		15	7		26	3
		4	93	620	2	6	8	49	27	1	82	11	
2001-2010		51	1236	6344	13	92	83	699	292	57	944	292	
62	2011	№ 1	17	132	1	3	1	9	2	1	15	2	
		№ 2	55	127			2		45	7	1	54	1
		№ 3	24	136			1	3	15	5		23	1
		№ 4	50	119			1	3	39	7		49	1
		4	146	514	1	7	7	108	21	2	141	5	
63	2012	№ 1	79	121		1	1	70	7		78	1	
		№ 2	55	119			2	3	42	8		50	5
		№ 3	46	134			1	3	35	7		45	1
		№ 4	67	155			1	3	54	9		55	12
		4	247	529	1	5	10	201	31	2	228	19	
64	2013	№ 1	26	133			3	2	13	8	25	1	
		№ 2	37	140			3	1	20	13	32	5	
		№ 3	58	168			1	2	44	11	47	11	
		3	121	441			7	5	77	32		104	17
2014-2015		Хэвлэгдээгүй											
65	2016	№ 1	30	100			5	3	15	7	27	3	
		№ 2	38	156			3	5	22	7	1	31	7
		№ 3	26	122			5	4	8	9		22	4
		3	91	378			13	12	45	23	1	80	14
66	2017	№ 1	31	104			7	5	11	8	25	6	
		№ 2	47	90	1			3	37	6		42	5
		№ 3	42	106			3	4	29	6		33	9
		№ 4	32	98	1	2	3		12	14		29	3
		4	152	398	2	12	15	89	34	1	129	23	
67	2018	№ 1	26	102			2	2	17	5	23	3	
		№ 2	34	102			3	3	18	10	29	5	
		№ 3	61	122			2	8	46	5	55	6	
		3	121	306	0	7	11	81	20	0	107	14	
68	2019	№ 1	62	112			2	3	50	7	59	3	
2020		Хэвлэгдээгүй											
69	2021	№ 1	56	164	1	4	1	24	26		46	10	
2011-2021		23	999	2862	5	57	64	692	194	6	894	105	
№	Он	Дугаар	Өгүүллийн тоо	Сэтгүүлийн хуудас	Тэргүүн /их бага хурал, тэмдэглэл	Судлал шүүмжлэл,	Дургал тэмдэглэл	Яруу найраг	Үргэлжилсэн үг	Тойм мэдээ /өлгөц/	Монгол	Гадаад /орчуулга/	
Дүн	77	342	7042	47,319	239	715	468	3422	1897	297	5718	1324	
<p>Энэхүү тоон үзүүлэлтийг нарийвчлан ашиглах бол дараах зүйлсийг анхаарна уу:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тоон үзүүлэлт нь сэтгүүлийн эх болон энэхүү “Цог сэтгүүлийн нийтлэлийн цахим мэдээллийн нэгдсэн сан”-1944-2021) бүтээлд зөрүүтэй буйг алдаа гэж үзэх шаардлагагүй. 2. 1990-д оноос урагш нэг зохиогчийн “Шүлэг, яруу найраг”-ийн төрлийг нэг бүтээл гэж үзсэн бол харин 1990-д оноос хойш нэг зохиогчийн олон шүлгийг номзүйн задлаг тодорхойлолтоор гаргасан учир тоо нэмэгдсэн. 3. Хүснэгтэд буй тоог сэтгүүлийн гарцагт тулгуурлаж хийсэн бол энэ бүтээлд нийтлэл тус бүрийг түүвэрлэж тайлбар бичилт үйлдсэн тул тоон хувьд илүү харагдах болно. 4. Нийт 77 жилийн хугацаанд 342 дугаарт 7000 гаруй өгүүлэл нийтлэл орсноос 78,5 % нь монгол, үлдсэн нь гадаад өгүүлэл нийтлэл болно. 5. МЗХ-с өнгөрсөн 77 жилийн турш нийт уншигчдад 2,9 мянга орчим хэвлэлийн хуудас бүхий сэтгүүлийн бүтээлийг бичиж туурвин, орчуулж боловсруулан нийтийн хүртээл болгожээ. 													

“Цог” сэтгүүлийн дугаарыг цахимжуулах үйл явц

Өнгөрсөн 77 жилийн хугацаанд Цог сэтгүүлийн 342 дугаар гарч, 7000 гаруй нийтлэл хэвлэгдсэний 80 орчим % нь монгол, үлдсэн нь гадаад өгүүлэл нийтлэл болно. Эдгээрээс дан шүлэг, яруу найраг, өгүүллэг, тууж, роман 75 %-ийг эзэлж үлдсэн нь утга, уран зохиолын холбогдолтой бодлого, Монголын зохиолчдын Эвлэлийн их бага хурал, зохиолчдын дуртгал, тэмдэглэл, шүүмж судлал, гадаад дотоодын уран зохиолын тойм мэдээ эзэлж байна.

Монголын Зохиолчдын Эвлэлийн Хорооны удирдлагын дагуу монголын болон гадаад улс орны зохиолчид судлаачид нар 2,9 мянга орчим хэвлэлийн хуудас бүхий сэтгүүлийн бүтээлийг бичиж туурвин, орчуулж боловсруулан нийтийн хүртээл болгожээ. Өөрөөр хэлбэл, төслийн явцад бид 47.319 хуудас буюу 2,957 орчим хэвлэлийн хуудас бүтээлийг канондох, зургийг фотогоор авах зэргээр цахим хэлбэрт оруулж ажиллаа. Олон хүний оролцоотойгоор богино хугацаанд хийж гүйцэтгэсэн учир сэтгүүлийн канондсан эх олон янз хэлбэртэй болсон ч цахимаар унших боломжтой юм. Бүрэн гаргацтай фотожуулсан хэсгийн ихэнх нь хувь хүний хадгаламжаас олсон, харин үдээс боодолтой, салгах боломжгүй зарим хэсэг нь номын сангуудаас авсан эх бөгөөд сэтгүүлийн шил хэсэгт заримдаа дарагдсан зүйл бас бий.

Сэтгүүлийн эхийг МУҮНС, УБХНТНС, МУИС, МУБИС, ХААИС, Утга зохиолын дээд сургуулийн номын сан, Хүүхдийн номын ордон, Дорнод, Ховд зэрэг аймгийн төв номын сан, МЗЭ-ийн номын дэлгүүр зэрэг газруудаас авч ашиглав. Мөн “Цог” сэтгүүлийн зөвлөл, эрхлэгч, хариуцлагатай нарийн бичгийн дарга, зохиол бүтээлээ нийтэлж байсан зохиолч нараас:

М.Саруулдалай /МЗЭ захирал-2020/

Я.Баяраа /хариуцлагатай нарийн бичгийн дарга 2017-2019/

Х.Зандраабайдий /Хариуцлагатай нарийн бичиг 2001-2009/

В.Сэлэнгэ /МЗЭ нарийн бичиг 2004-2020/; Мөн Э.Цагаан-уул /Соёлын гавьяат зүтгэлтэн яруу найрагч А.Эрдэнэ-Очирын хүү/, Д.Энхболд /Зохиолч/, Б.Бааст /МУ-ын хөдөлмөрийн баатар, Ардын уран зохиолч /түүний ач охин/, С.Дулам /Ардын багш, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн/ зэрэг хүмүүстэй холбогдож, уулзаж яриа авч сэтгүүлийн зарим дугаар хэвлэгдээгүй тасалдсан тухай (1993-2000) асууж тодруулан ажилласан болно.

Үр дүн 2: 7042 нийтлэл тус бүрийг “Zotero” программд оруулсан үйл явц

Бидний судалгаагаар тус сэтгүүлийн 342 дугаарын 7042 нийтлэл тус бүрийг “Zotero” программд шивж 10-с дээш үзүүлэлтээр хайх боломж бүрдлээ. **Хүснэгт № 2**


“Цог” сэтгүүлийн нийтлэлийг “ZOTERO”- програмд оруулсан загвар ба өгөгдлийн нэрийн оногдуулалт

№	Англи нэр	Монгол	Жишээ загвар
1	Title	Нийтлэлийн Гарчаг	“Үүрийн туяа”
2	Author	Зохиогч	Ринчен Б
3	Translator	Орчуулагч	/гадаад нийтлэл бол орчуулагчийг бичнэ/
4	Abstract	Товч тайлбар	Түүхэн роман: Тэгшхэн зассан дэлтэй, хад мэт хантраастай, сайхан халтар морь, зүүн гаргай цулбуураа бариад, урт гансаа яаралгүй бариа татаж суусан эзнээ байн байн харж, соргог хоёр чихээ солбилзуулан зогсож байлаа...
5	Publication	Хэвлэсэн газар	УБ./хэвлэгдсэн газар/
6	Volume	Дугаар /№/	№ 3-4
7	Date	Хэвлэгдсэн он	1950
8	Pages	Хуудас	38 х.
9	Series	Цуврал	Цог
10	Language	Хэл	Монгол
11	Library Catalogy	Номын сангийн каталоги	(ДАА) 808,5
12	Call Number	ЗҮДЗТ	P-518
13	Short Title	Дэд гарчаг	-
14	ISSN	Олон улсын дугаар	-
15	Url	-	-
16	Accessed	Хандалт	-
17	Archive	Архив	-
18	Loc.in Archive	Хаана байгаа	номын сангийн нэр
19	Rights	-	-
20	Exstra		-
21	Date Added	Нэмсэн огноо	Шивсэн он сар, өдөр гарна
22	Modified	Өөрчлөгдсөн	
ДҮН		22 үзүүлэлтээс	13 Үзүүлэлтээр хайна.

Дээрх программ нь тогтмол хэвлэлийн мэдээлэл оруулахад зориулагдсан өгөгдөлтэй, номзүйн лавлагаа мэдээллийн нээлттэй, үнэ төлбөргүй програм бөгөөд онлайн байх шаардлагагүй тул хаанаас ч хандах боломжтой ашиглахад хялбар юм. Өөрөөр хэлбэл, “Цог” сэтгүүл бол нэг хэмжээ, хэлбэр, хийц, нэг нэр төрлийн, нэг дугаарын үргэлжлэл, буюу нэг он сараар өдөрлөсөн, агуулгаараа үл давтагдах жил бүр тогтсон номер дугаараар зохион байгуулагддаг, тодорхой цаг хугацааны хооронд хэвлэгдэж ирсэн хэвлэл тул олон улсын энэ программыг сонгоход

тохиромжтой гэж үзлээ. АНУ-ын Жорж Мейсоны Их Сургуулийн Түүх, Шинэ Хэвлэл мэдээллийн төвөөс боловсруулан гаргасан Zotero программыг (Google Chrome, Mozilla Firefox, Apple Safari, Opera-д зориулсан өргөтгөлтэй) хот хөдөөгийн аль ч номын сан мэдээлэл цуглуулж, хадгалах, бүрэн вэб хуудас нэмж оруулах боломжтой. Zoteroгийн давуу тал бол өгөгдөлд тохирсон материал дээр үндэслэн ном зүй гаргаж, ишлэл үүсгэх чадвар бөгөөд гол агуулга нь Номын нэр, Зохиогч, Хуудасны дугаар, Хэвлэгдсэн он, Хэвлэн нийтлэгч гэх мэт үндсэн лавлагааны агууламжтай, программын баруун дээд талд буй (Info, Notes, Tags, Related) талбаруудад нэмэлт тэмдэглэл оруулж, үүссэн цахим мэдээллээ төрөлжүүлэн ангилах, /байгууллагын ажлын тайлан, илтгэл, өгүүлэл гэх мэт/ хайх, засварлах, шинэчлэх боломжтой. Цаашилбал, Zoteroгийн бүтэцтэй /эмхэтгэл, байгууллага, иш таталт, синк хийх, хамтран ажиллах/ дэлгэрэнгүй танилцаж, сэтгүүлийн бичвэр, зохиогчийн нэр, нийтлэлийн гарчаг, тоо болон хураангуй товчлол, түлхүүр үгс болон монгол, гадаад аль ч хэлнээс иш татах боломжтой.

Зураг № 3: 1947 оны Цог сэтгүүлийн нийтлэлийг “ZOTERO”- д оруулсан загвар



Бид цаасан картын санд тулгуурлан цахимд мэдээлэл оруулсан, харин төслийн урьдчилсан хэлэлцүүлгээр цаасан картыг орчин үед төдийлөн хэрэглэхгүй болсон тул давхар хийх шаардлагагүй гэж зөвлөснийг үндэслэн цаашид цахимаар хийхээр болсон билээ.

Зураг №4: Цог сэтгүүлийн цаасан картын сан (1944-2021)



Үр Дүн 3: “Цог” сэтгүүлийн нийтлэлийг хэвлэмэл гарын авлага

1944-2021 оны хооронд хэвлэгдсэн “Цог” сэтгүүлийн 7000 гаруй нийтлэлийг эмхтгэн нэгтгэж, цаасан хэлбэрээр “Цог сэтгүүлийн нийтлэлийн цахим мэдээллийн нэгдсэн сан” - /1944-1980/, /1981-2021/ нэртэй 2 дэвтэр эмхтгэл бүтээлийг цөөн хувиар хэвлэн гаргаж архивлан үлдээж байна. Цаасан суурьтай, хэвлэмэл эхийг хийхдээ бид эхлээд он дараалал, дотор нь үсэг дараалал, үсэг дараалал дотор нэг зохиогчийн бүтээлийг дахиад он дараалалд оруулах дэс дарааллыг эрхэмлэж, нийтлэл тус бүрд товч тайлбар хийсэн болно. Энэ нь хайлт хийхэд дөхөм болох номзүйчлэлийн олон улсын тогтсон арга билээ. Харин нэг он дотроо үсэг дараалалд орсон тул сэтгүүлийн дэс дугаар үсэг дараалалд өмнө хойноо орсон болохыг анхаарч ашиглана уу. Жишээ нь, 1944 оны 1, 2, 3, 4 дугаарын нийтлэлүүд нэг үсэг дараалалд орсон болно. Мөн хэвлэгдээгүй, тасалдсан онуудыг дотор нь бичиж сануулсан, товч тайлбарууд нь бусад хэвлэлийн бүтээлээс ялгарах онцлогтой, тухайлбал, шүлэг, яруу найраг, өгүүллэг, тууж г.м. уран зохиолын онцлог шинжид тохируулан нийтлэлийн эхний мөрөөс заримдаа эшэлсэн бол утга зохиолын шүүмж судлал, тэмдэглэл, дуртгалд агуулгын товчийг гаргаж өгсөн болно.

Нэг хүний нэр өөр өөрөөр бичигдсэн зүйл байна, тухайлбал, 1960-аад оноос өмнө Ринчин гэж бичиж байсан бол түүнээс хойш Ринчен хэмээн бичсэн, зарим хүний овог бичигдээгүй г.м. уг эх нийтлэлд хэрхэн бичигдсэнийг тэр хэвээр нь мэдээлэлд авлаа.



Мэдээллийн санг ашиглахад анхаарах зүйл:

Хүснэгт 2-д болон энэхүү хэвлэмэл эхэд харуулсан тоон үзүүлэлтийг нарийвчлан ашиглах бол дараах зүйлсийг анхаарна уу:

1. Сэтгүүлийн нийтлэлийн тоо 1990-д оноос урагш “Шүлэг, яруу найраг”-ийн төрлөөр бага үзүүлэлттэй юм. Учир нь нэг зохиогчийн шүлгийг нэг гэж тоолсон, мөн нэргүй шүлгийн мөртүүдийг баримжаалин тооцсон болно. Харин 1990-д оноос хойш нэг зохиогчийн олон шүлгийг номзүйн задлаг тодорхойлолтын аргаар тоолж гаргасан учир тоо нэмэгдсэн.
3. Хүснэгтэд байгаа тоог голлон сэтгүүлийн гарчагт тулгуурлаж хийсэн бол дэвтэрлэж хэвлэсэн номзүйн бүтээлд нийтлэл тус бүрийг түүвэрлэж тайлбар бичилт үйлдсэн тул тоон хувьд илүү харагдах болно.
4. Нэг зохиогчийн олон шүлэг найраглал, өгүүллэг, нийтлэл зэрэг байвал: Шүлгүүд, Нийтлэлүүд, Өгүүллэгүүд, Найраглалууд гэж гарчагт бичсэн ба харин Тайлбар хэсэгт бүтээлийн нэр тус бүрээр тодорхойлолт өгсөн.

5. Сэтгүүлийн хэвлэлд заримдаа МЗЭ-ийн хэвлэл, заримд нь бичээгүй тул энд оруулаагүй, мөн 1944 оноос эхлэн давхар дугаартай явж байснаа заримдаа орхигдсон, нэг бол давхардсан зэрэг хэвлэлийн алдаа байгаа тул жигдлэн ерөнхий дугаараар орууллаа.
6. Гадаад зохиолчдын төрсөн он, хаанахын хүн гэдгийг заримдаа бичсэн, бичээгүй байгаа тул байгаагаар нь тодорхойлов.
7. Сэтгүүлийн зарим хуудас урагдаж гэмтсэн, заримынх нь гарчаг олохгүй, заримдаа бичвэр дотроо төрөлжүүлэн гарчагласан, нэг бол хойноо орсон, гарчагт буй нэр үндсэн бичвэр дэх нэртэй зөрүүтэй зэрэг хайлт хийхэд төвөгтэй зүйл багагүй тохиолдсон нь Zotero програмд мэдээлэл оруулахад цэг, таслал, зураас, зай, овгийн үсгийг ард оруулах г.м. нягт нямбай арга ажиллагааг шаардаж байв. Иймд цаашид цахим хайлт хийхэд зарим мэдээлэл зөрүүтэй гарч ирэх магадлал байгаа тул залруулан ойлгоно гэдэгт итгэж байна.
8. . Бид анх 1947-2020 он хүртэлх мэдээллийн сан хийхээр төлөвлөсөн ч шинээр 1944, 1945, 1946 онуудыг нэмж хийснээс гадна баримжаа тоогоор 500 нэрийн сэтгүүл гэж тооцсон ч дундаа тасарч хэвлэгдээгүй учир энэхүү хүснэгтэд тэмдэглэсэн 342 сэтгүүл бол хэвэгдэж гарсан бодит тоо болно.
9. Манай улсын томоохон номын сангуудад 1960-д он хүртэлх тогтмол хэвлэлийн хадгалалт хамгаалалт, бүрэн байдал алдагдаж, нилээд хуучирч муудсан, тоосжилт их, уншигчийн ашиглалтаас шалтгаалж урагдаж гэмтсэн, үдээс оёос нь үсгээ дарсан зэрэг уншихад төвөгтэй зүйл олон байлаа. Цаашид улсын хэмжээний болон салбарын мэдээллийн сангийн бүрдлийг нэгдсэн бодлого, шийдвэр, нэг индекс, кодтой хийж, олон улсын номзүйн мэдээллийн стандартад нийцүүлэх шаардлагатай юм.

Төгсгөл: “Цог” сэтгүүлийн гаралтын мэдээний тойм

XX зууны эхнээс үүсэж хөгжсөн монголын орчин үеийн тогтмол хэвлэлийн томоохон төлөөлөлд “Цог” сэтгүүл зүй ёсоор орно. 1940-ээд оноос шинэ үеийн уран зохиолыг хэвлэн нийтлэх тогтмол хэвлэл хэрэгтэй болж, 1942-1943 онд олон шүлгийн “Цоморлог” дэвтрийг анх гаргаж эхэлсэн нь одоогийн Цог сэтгүүлийн суурийг тавьсан байна. Цоморлог сэтгүүлд дан шүлэг яруу найргийг хамруулж үргэлжилсэн үгийн зохиол орхигдож байсан учир хэлэлцээд нэрийг өөрчилж “Цог” хэмээх нэртэй, уран зохиолын төрөл зүйлийг багтаасан утга зохиолын сэтгүүл болгож 3 сар тутамд нэг удаа зохиолчдын түр хорооноос эрхлэн гарах болсон.

МАХН-ын ТХ-оос 1943 онд гаргасан тогтоолдоо “Цог” сэтгүүлийг эрхлэн гаргахыг МЗЭ-д даалгаснаар 1944 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр анхны дугаар 5000

хувь хэвлэж /2004 оны №2-ын 5-р талд/, хариуцлагатай эрхлэгчээр эрдэмтэн Бямбын Ринчен ажилласан байдаг. Сэтгүүлийн эхний дөрвөн дугаарыг монгол бичгээр хэвлэж /1945 оны №5,6- с бусад/, харин тав, зургаа дахь дугаараас шинэ үсгээр хэвлэсэн юм.

1954 оныг дуустал улиралд 1 дугаараар, харин 1955-1991 он хүртэл жилд 6 дугаараар гарч, дотоод, гадаадын утга, уран зохиолын нэрт хүмүүсийн уран бүтээлтэй танилцуулж эхэлснээр монголын нийт уншигчдын хүсэн хүлээсэн хэвлэл болж, өдгөө 80 шахам жил үргэлжлэн уншигдсаар буй. 1974 онд “Цог” сэтгүүлийн 30 жилийн тохиож “...Ардын их хурлын тэргүүлэгчдийн зарлиг гарсанд: хөдөлмөрчдийн коммунист үзэл санаагаар хүмүүжүүлэх, социалист реализмын утга зохиолыг хөгжүүлэх, өөрийн орны болон ЗХУ, ах дүү социалист орны утга зохиолыг сурталчлах, зохиолчдын ур чадварыг дээшлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж “Алтан гадас” одонгоор шагналаа” /ойн ёслол 1975 оны 1-р сарын 9-нд болсон/ гэж тэмдэглэсэн нь сэтгүүлийн өнгөрсөн 30 жилийн түүхэн дэх ерөнхий агуулга гэж үзэж болно. Харин Ардчиллын эхний жилүүдэд “Цог” сэтгүүл хэвлэгдэх боломжгүй болж 1993-2000 оны хооронд хэсэг хугацаанд тасалдсан байна. 1992 онд 4 дугаараар гарч, улмаар 1993 оны эхний хоёр дугаарыг бэлтгэсэн боловч хэвлэгдээгүй тул гол зохиолууд нь "Утга зохиол" сонины тусгай дугаарт нийтлэгдсэн байна. Мөн “Цог” сэтгүүлийн 50 жилийн ой 1994 онд тохиосон учир ойд зориулсан дугаарыг “Соёл урлагийг дэмжих сан”-гийн ивээн тэтгэлгээр хэвлүүлсэн гэж сурвалжилж тэмдэглэсэн (Л.Ч) ч олдоогүй. /МУҮНС-д байхгүй/. Зах зээлт шинэ нийгмийн төвөгтэй цаг үед сэтгүүл хэдий тасалдсан ч оюунлаг ивээн тэтгэгчдийн оролцоо, сэтгүүлийн редакцийн зөвлөлийн хичээл зүтгэлээр 2001 оноос Х.Алтангэрэл захиралтай “Хөгжил трейд”¹ компанийн ивээн тэтгэлгээр улирал тутам дахин хэвлэгдэх болсон билээ. Энэ мэт тус сэтгүүл 2001 оноос хэвлэлийн захиалгад орж хот, хөдөөгийн уншигчдын захиалга өссөн, Өвөр Монголын шинэ монгол бичгээр хэвлэгдсэн “Өнөр Цэцэг” сэтгүүлийн тусгай дугаар хэвлэгдсэн, мөн дахиад зарим оны сэтгүүлийн дугаар тасалдсан /2013, 2014, 2015, 2020/, МЗЭХ өөрсдийн санхүүжилтээр сэтгүүлээ гаргах болсон зэрэг онцлог зүйлүүдийг тоймлон тэмдэглэж байна. Түүнчлэн сэтгүүлийн 60, 70 жилийн ойн арга хэмжээ, удахгүй болох 80 жилийн ой гэх мэт уншигч, нийтлэгчдийн эрэлт хэрэгцээ, түүхэн хамт олны хичээл зүтгэл, сэтгүүлийн редакцийн нөр их хөдөлмөр үргэлжилсээр байна.

¹ Сэтгүүлийн нүүр хуудсанд: Нийгэм, утга зохиол, уран сайхны СЭТГҮҮЛ. МЗЭ “Хөгжил трейд” компани. 2001 № 01 (269) гэжээ

Талархал

“Цог” сэтгүүлийн цахим мэдээллийн сан” Төслийг ивээн тэтгэж санхүүжилт олгосон ШУА, ШУТС, төслийг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжиж тусалсан СУИС-ийн СС-ийн удирдлага, санхүүгийн алба, НССТэнхимийн хамт олонд талархлаа илэрхийлье. Энэхүү төслийг хэрэгжүүлэх явцад “Цог” сэтгүүл нь уншигчдын эрэлт хэрэгцээ ихтэй, танин мэдэхүйн ач холбогдолтой хүлээлттэй хэвээр байгаа хэвлэл тул тасалдуулахгүй хэвлэн гаргах бүх талын арга хэмжээ авч ажилласан сэтгүүлийн редакцийн хамт олон болон ивээн тэтгэж ажилласан Х.Алтангэрэл захиралтай “Хөгжил трейд” компанид нийт уншигчдын нэрийн өмнөөс талархал илэрхийлж байна. Зах зээлийн шилжилтийн үед сэтгүүл хэвлэгдэхгүй тасалдах болсон шалтгаан, эрэл сургийг тодруулж өгсөн зохиолч Х.Зандраабайдий, Б.Баастын хувийн цуглуулгаас зарим сэтгүүлийн гарчгийг хуулбарлуулсан /ач охинд/ явдалд талархаж байна. Цог сэтгүүлийн нийтлэлээр цаасан картын даалгавар гүйцэтгэж, дадлага хийсэн оюутан, магистрантууд, сэтгүүлийн мэдээллийг судалсан магистр Л.Чимэдцэрэн, оюутан Б.Бүжинлхам, номын санч Э.Ууганбаяр, Д.Шинэчимэг нарт талархал илэрхийлье.

Төслийн удирдагч:

Тайлан бичсэн:

Ж.Цэзэн

2023.04.3